

Аудитын код: САГ-2018/4/СТА-ЗГТС

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу:

Цахим хуудас: www.audit.mn

Санхүүгийн аудитын газрын захирал бөгөөд тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг

Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn


Аудитын менежер Г.Гүнжидмаа

Утас: 261885 Цахим хаяг: gunjidmaag@audit.gov.mn

Ахлах аудитор Ц.Хосжаргал

Утас: 261628 Цахим хаяг: khojiargalts@audit.gov.mn

Улаанбаатар хот



АГУУЛГА

Аудитын гэрчилгээ.....	0
<u>1</u> Аудитын тайлан	1
1.1 Оршил.....	1
1.2 Аудит хийх хууль, эрх зүйн үндэслэл.....	1
1.3 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа	2
1.4 Аудитын шалгуур үзүүлэлт, арга зүй, хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн....	2
1.5 Дотоод хяналт	3
1.6 Төсвийн орлого, зардлын гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	3
1.7 Шилэн дансны мэдээлэл	4
1.8 Төлөвлөлтийн шатанд тооцсон эрсдэл, түүний үр дагавар	4
1.9 Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл	4
1.10 Анхаарал татахуйц бусад чухал асуудал	4
1.11 Аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл	4
1.12 Залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар	5
1.13 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	5
1.14 Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар.....	5
1.15 Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	5
<u>2</u> Менежментийн захидал.....	6
2.1 Зардал	7
3. Аудит хийгдсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл.....	8
3.1. Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан.....	8
3.2. Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	9
3.3. Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан	10
3.4. Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	11
3.5. Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	11



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:62-26-32-30
E-mail: info@audit.gov.mn

2018.03.23 № 06/818
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Засгийн газрын нөөц сангийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Засгийн газрын нөөц сангийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж Сангийн сайдын баталсан бодлого, аргачлал, журмын дагуу үнэн, бодит, шударга, илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Засгийн газрын нөөц сангийн 2017 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэлтэй санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

САНГИЙН САЙД
Ч.ХҮРЭЛБААТАР ТАНАА



071453

Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлсэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ
БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ



01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ

1 Аудитын тайлан

1.1 Оршил

Засгийн газрын нөөц сангийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайланг Сангийн сайд Ч.Хүрэлбаатар танд танилцуулж байна.

Энэхүү тайланд танай байгууллагын санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, залруулаагүй материаллаг бус алдаа зөрчлийн болон өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт, үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудит хийгдсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Менежментийн захидалд үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитын явцад Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагад дурдсан аудитын төлөвлөлт, гүйцэтгэл, тайлагналын үе шатны ажлыг гүйцэтгэж, баримтжуулан аудитад баримталсан стандарт, зарчим, үйл явцын талаарх мэдээллийг аудитын санал дүгнэлтэд тодорхойлсон болно.

1.2 Аудит хийх хууль, эрх зүйн үндэслэл

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Засгийн газрын нөөц сангийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Аудитыг Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандарт, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Засгийн газрын нөөц сангийн 2017 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт /УСНББОУС/, түүнд нийцүүлэн гаргасан төрийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2018 оны 2 дугаар сарын 26-ноос 2018 оны 3 дугаар сарын 23-ны хооронд хийж, аудитын тайланг 2018 оны 3 дугаар сарын 25-нд эцэслэн баталгаажуулж, төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Үндэсний аудитын газрын Санхүүгийн аудитын газрын ахлах аудитор Ц.Хосжаргал аудитыг гүйцэтгэв.

01

ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ

Сангийн сайд Засгийн газрын нөөц сангийн 2017 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг 2018 оны 1 дүгээр сарын 25-ны өдрийн 11-2/397 дугаар албан бичгээр Үндэсний аудитын газарт хуулиар тогтоосон хугацаанд ирүүлсэн байна.

1.3 БАЙГУУЛЛАГЫН ЗОРИЛГО, ҮЙЛ АЖИЛЛАГАА

Засгийн газрын нөөц сангийн үйл ажиллагаа нь Засгийн газрын тусгай сангийн тухай хуулиар зохион байгуулагдаж, тухайн жилийн төсөвт урьдчилан төлөвлөж тусгах боломжгүй дор дурдсан арга хэмжээг санхүүжүүлэхэд зарцуулагдана. Үүнд:

- Гамшиг, аюулт үзэгдэл тохиолдсон, нийтийг хамарсан цөмийн болон цацрагийн осол гарсан үед түүний хохирлыг бууруулах, тархалтыг хязгаарлах, үр дагаврыг арилгах;
- Үйлдвэрлэл, технологийн горим зөрчигдсөнөөс барилга байгууламж, шугам, сүлжээ, тоног төхөөрөмж эвдрэх, тээврийн хэрэгсэл сүйрэх, цацраг идэвхт болон химийн хорт бодис алдагдах зэрэг техникийн холбогдолтой томоохон осол гарсан тохиолдолд түүнийг таслан зогсоох, хохирлыг арилгах;
- Алан хядах ажиллагаа, дэлбэрэлтийн улмаас олон хүний эрүүл мэнд, амь нас, эд хөрөнгө, хүрээлэн байгаа орчинд учирсан хохирлыг арилгах;
- Төсвийн жилийн явцад шинээр батлагдсан хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийг хэрэгжүүлэхэд шаардагдах нэмэлт зардал;
- Засгийн газар олон улсын шүүх, арбитраг хариуцагчаар татагдсан буюу тэдгээрээс гарсан шийдвэрийг биелүүлэхэд шаардагдах зардал;
- Олон улсын гэрээний дагуу Монгол Улс төлөх, тухайн жилийн төсөвт тусгагдаагүй татвар, төлбөр, хураамж;
- Байгууллага, иргэдээс тавьсан хүсэлт болон цаг үеийн шинжтэй зарим асуудлыг шийдвэрлэхэд шаардагдах зардал.

Засгийн газрын нөөц сангийн үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд төлөвлөсөн хэмжээнд судалж, баримтжуулсан.

1.4 АУДИТЫН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ, АРГА ЗҮЙ, ХЭРЭГЖҮҮЛСЭН ГОРИМ СОРИЛ, ТҮҮНИЙ ҮР ДҮН


Аудит хийхэд Аудитын олон улсын стандарт, Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт 1000 - 1810 буюу Санхүүгийн аудитын удирдамж, Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

Аудитаар Засгийн газрын нөөц сангийн 2017 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санал дүгнэлт өгөх зорилгоор тэдний бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн дансдын уламжлалт болон хяналтын эрсдэлийг үнэлснээс гадна удирдлагаас тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа.

Дотоод хяналтын талаарх гол асуудал, дүгнэлтийг энэ тайлангийн 2.5-д үзүүлэв.

Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын 2 чиглэлээр түүвэрчилсэн байдлаар аудитын 15 горим, сорил гүйцэтгэв.

Эдгээр горим сорилыг хэрэгжүүлэх явцад илэрсэн алдаа, зөрчилтийг зарим тоо асуудлыг энэ тайлангийн 2.9 дэх заалтад хураангуйлан тэмдэглэв.



Засгийн газрын нөөц сангийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн төвөгтэй байдлыг үнэлэхэд эрсдэл “бага” буюу мэдээллийн технологийн мэргэжилтэн аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Засгийн газрын нөөц сангийн санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд “PTSan” програм ашиглажээ.

1.5 Дотоод хяналт

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Санхүүгийн үйл ажиллагаанд өдөр тутам удирдлага дотоод хяналтыг хэрэгжүүлдэг байна. Сангийн зарцуулалтын санхүүжилтийг Засгийн газрын тогтоолын дагуу Сангийн сайдын зөвшөөрлөөр шилжүүлж, гүйцэтгэлийг эрх бүхий албан тушаалтан хянадаг байна.

1.6 Төсвийн орлого, зардлын гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга


Засгийн газрын нөөц сангийн 2017 оны төсвийн урсгал санхүүжилт 33,852.0 сая төгрөгөөр батлагдаж, гүйцэтгэлээр бүрэн санхүүжигдсэн байна.

Тайлант онд санхүүжилтийн орлогоос гадна өмнөх оны Төв төрийн санд татан төвлөрүүлсэн Тогтворжуулалтын санд төвлөрүүлэх 374.6 сая төгрөг, МИАТ ТӨХК-иас авах авлагаас 183.9 сая төгрөгийн орлого орсон байна.

Сангийн нийт зарцуулалт 28,883.3 сая төгрөг буюу 85.3 хувийн гүйцэтгэлтэй байна.

Нийт зарцуулалтыг хуульд заасан зориулалтаар нь авч үзвэл:

Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд заасан зориулалт	Тогтоолын дүн	Олгогдсон дүн	/сая төгрөгөөр/	
			Гүйцэтгэл	Нийт гүйцэтгэлд эзлэх хувь
8.3.1.гамшиг, аюулт үзэгдэл тохиолдсон, нийтийг хамарсан цөмийн болон цацрагийн осол гарсан үед түүний хохирлыг бууруулах, тархалтыг хязгаарлах, үр дагаврыг арилгах;	17,360.3	16,209.1	16,202.1	56.1%
8.3.4. төсвийн жилийн явцад шинээр батлагдсан хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийг хэрэгжүүлэхэд шаардагдах нэмэлт зардал;	8,319.6	8,319.6	8,289.1	28.7%
8.3.7. байгууллага, иргэдээс тавьсан хүсэлт болон цаг үеийн шинжтэй зарим асуудлыг шийдвэрлэхэд шаардагдах зардал;	3,506.8	3,695.9	3,572.5	12.4%
8.4.Гамшгийн хор уршгийг арилгахад зориулан гадаад улс, олон улсын байгууллага, түүнчлэн гадаад, дотоодын байгууллага, иргэн, хуулийн этгээдээс өгсөн буцалтгүй тусламж, хандивын хөрөнгийг тухайн зориулалтаар нь зарцуулах бөгөөд уг хөрөнгө нь хүрэлцэхгүй бол Засгийн газрын нөөц сангаас санхүүжүүлнэ;	354.0	354.0	354.0	1.2%
Нууц тогтоолоор	466.2	466.2	465.7	1.6%
Дүн	30,006.9	29,044.8	28,883.4	100.0%



Зарцуулагдаагүй санхүүжилтийн үлдэгдэл 4,968.6 сая төгрөгийг Тогтворжуулалтын санд төвлөрүүлэхээс 4,937.7 сая төгрөг төвлөрүүлж, 31.9 сая төгрөгийг Төв төрийн санд татан төвлөрүүлсэнийг авлага, Тогтворжуулалтын санд өгөх өглөгөөр тусгасан байна.

1.7 Шилэн дансны мэдээлэл

Засгийн газрын нөөц сан “shilendans.gov.mn” цахим хуудсанд сангийн батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан, тайлбарыг хамт сар бүр мэдээлсэн байна.

1.8 Төлөвлөлтийн шатанд тооцсон эрсдэл, түүний үр дагавар

Аудитын төлөвлөгөөний дагуу тохиолдох магадлалтай дансанд хамаарах уламжлалт болон хяналтын эрсдэлийг агуулж байж болзошгүй гэж урьдчилан тооцоолсон бөгөөд батламж мэдэгдлүүдийн хүрээнд 4 аудитын чиглэлд нийт 15 нарийвчилсан горим, сорил гүйцэтгэлээ.

Хэрэгжүүлсэн горим сорилын үр дүнг гүйцэтгэлийн үе шатны “Төлөвлөсөн горим, сорилуудыг хэрэгжүүлж, үр дүнг аудитын чиглэл тус бүрээр баримтжуулах” гэсэн үе шатны ажилд хамааруулан маягтаар данс тус бүрээр баримтжуулсан болно.

Дээрх горим сорилыг хэрэгжүүлэх явцад илэрсэн зарим зөрчилтэй асуудлыг энэ тайлангийн 2.9-д хураангуйлан тэмдэглэв.

1.9 Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл

Засгийн газрын нөөц сангийн хөрөнгөөс хөрөнгө оруулалт болон урсгал төсвөөс санхүүжигдэх боломжтой зардлуудыг зарцуулсан дараах алдаа, зөрчил байна. Үүнд:


- Гадаад томилолт, гадаад зочны зардал, олон улсын чуулга уулзалтад 227.7 сая төгрөг;
- Говьсүмбэр аймгийн төвийн халаалтын зориулалтаар худалдан авсан уурын зуухны 170.0 сая төгрөгийн гааль болон нэмэгдсэн өртгийн татвар;
Шийдвэрлэсэн: Цаашид хөрөнгө оруулалт болон урсгал төсвөөс зарцуулагдах зардлыг сангийн хөрөнгөөс санхүүжүүлэхгүй байх зөвлөмж өглөө.

1.10 АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ

Засгийн газрын 2014 оны 155 дугаар тогтоолоор МИАТ ТӨХК-ийн "Боинг 767-300ER" агаарын хөлөг худалдан авах Засгийн газрын баталгаатай үндсэн болон зээлийн 3 дахь төлбөрийн буцаан төлөх нөхцөлтэй нийт 4.2 сая ам.доллар буюу 7,541.3 сая төгрөгийг Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3.4 дэх заалтыг үндэслэн Засгийн газрын нөөц сангаас олгосон байна. МИАТ ТӨХК-иас авах нийт авлагаас 3,678.0 сая төгрөг барагдаж, хугацаандаа төлөгдөөгүй авлагын дүнд тооцсон алданги 1,442.9 сая төгрөг нийт 5,306.2 сая төгрөгийн авлагатай байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.7 дахь “төрөөс хэрэгжүүлэх аливаа үйл ажиллагаа, хөтөлбөр, арга хэмжээ, татвар ногдуулалт, эсхүл хөнгөлөлт, баталгаа, зээл, өр төлбөр, санхүүгийн үйл ажиллагаа, болзошгүй өр төлбөр, тэдгээрийн үр дүн нь өнөө болон ирээдүй үеийн хооронд тэгш бус байдал үүсгэхгүй байх” заалттай нийцэхгүй байна.

1.11 АУДИТААР ИЛЭРСЭН ЗӨРЧИЛНИЙ НЭГТГЭЛ

Засгийн газрын нөөц сангийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийт 397.7 сая төгрөгийн зөрчилд зөвлөмж өглөө.



1.12 Залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар

Аудитаар илэрсэн 397.7 сая төгрөгийн зөрчил нь Засгийн газрын тогтоолоор тусгай сангийн хөрөнгийг урсгал зардал болон хөрөнгө оруулалтын зардалд санхүүжүүлэх боломжтой арга хэмжээг зарцуулсан тул залруулагдах боломжгүй юм.

1.13 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны аудитаар зөвлөмж өгөгдөөгүй байна.

1.14 МАТЕРИАЛЛАГ БАЙДЛЫН СУУРЬ СОНГОСОН ҮНДЭСЛЭЛ, ТАЙЛБАР

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үеийн материаллаг байдлыг Аудитын олон улсын стандарт 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр төсвийн зардлын гүйцэтгэлийг сонгов.

Засгийн газрын тусгай сангийн 2017 оны төсвийн зардлын гүйцэтгэл 28,883.4 сая төгрөг бөгөөд 2.0 хувиар буюу 557.7 сая төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

1.15 САНАЛ ДҮГНЭЛТИЙН ХЭЛБЭР, ҮНДЭСЛЭЛ

Бид Засгийн газрын нөөц сангийн 2017 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг баталгаажуулах ажлыг Аудитын олон улсын стандартын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Засгийн газрын нөөц сангийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн болон илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн байна гэж үзэж “Зөрчилгүй” санал дүгнэлт гаргалаа.

Аудитын явцад илэрсэн зөрчлийн талаарх үнэлэлт дүгнэлтийг энэ тайлангийн 2.12-д тусгасан бөгөөд залруулаагүй алдаа, зөрчлийг материаллаг байдлын түвшинтэй харьцуулахад аудитын санал дүгнэлтийг хязгаарлах үндэслэлгүй байна.



2 МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Үндэсний аудитын газар аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгчид зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүүгийн хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг билээ.

Энэхүү менежментийн захидлын агуулга Аудитын олон улсын стандарт болон аудитын горимоос урган гарсан болно. Санхүүгийн тайлангийн талаар санал дүгнэлт гаргахад бидний горим зориулагдсан.

Энэ нь Сангийн яамны нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан санхүүгийн ажилтнууд болон холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг ач холбогдлынх нь дарааллаар эрэмбэлэн дор нэгтгэн харуулав.



2.1 Зардал

Тэргүүлэх ач холбогдол №1

ҮАГ-ын ажиглалт

- Гадаад томилолт, гадаад зочны зардал, олон улсын чуулга уулзалтад 227.7 сая төгрөг;
- Говьсүмбэр аймгийн төвийн халаалтын зориулалтаар худалдан авсан уурын зуухны 170.0 сая төгрөгийн гааль болон нэмэгдсэн өртгийн татварыг тусгай сангийн хөрөнгөөс зарцуулсан.

ҮАГ-ын зөвлөмж

Цаашид хөрөнгө оруулалт болон урсгал төсвөөс зарцуулагдах хөрөнгийг сангийн хөрөнгөөс санхүүжүүлэхгүй байх зөвлөмж өглөө.

Зөвлөмжийн хэрэгжилтийг 2018 оны 09 дүгээр сарын 01-ний дотор гаргаж Үндэсний аудитын газарт ирүүлэх.

Эрсдэлүүд

Сангийн хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулахад хөрөнгө дутагдах

Төсвийн захирагчийн хариу

Асуудлын бүртгэлээр удирдлагад танилцуулж баталгаажуулав.

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

**ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ**

3. Аудит хийгдсэн САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

3.1. Аудит хийгдсэн САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	5,503,612,150.51	5,338,144,047.69
33	АВЛАГА	5,503,612,150.51	5,338,144,047.69
33500	Бусад авлага	5,503,612,150.51	5,338,144,047.69
33510	Байгууллагаас авах авлага	5,503,612,150.51	5,338,144,047.69
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	5,503,612,150.50	5,338,144,047.69
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	374,555,936.30	31,890,291.34
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	374,555,936.30	31,890,291.34
41300	Өглөг	374,555,936.30	31,890,291.34
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	374,555,936.26	31,890,291.34
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	5,129,056,214.25	5,306,253,756.35
51	Засгийн газрын хувь оролцоо	5,129,056,214.25	5,306,253,756.35
51200	Хуримтлагдсан үр дүн	5,129,056,214.25	5,306,253,756.35
51210	Өмнөх үеийн үр дүн	3,192,012,070.25	5,129,056,214.25
51220	Тайлант үеийн үр дүн	1,937,044,144.00	177,197,542.10
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	5,503,612,150.51	5,338,144,047.69



3.2. Аудит хийгдсэн САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	25,936,703,058.30	34,213,175,446.40
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	936,703,058.30	361,175,446.40
120	Нийтлэг татварын бус орлого	936,703,058.30	361,175,446.40
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	936,703,058.30	361,175,446.40
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	936,703,058.30	361,175,446.40
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	25,000,000,000.00	33,852,000,000.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	25,000,000,000.00	33,852,000,000.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	25,000,000,000.00	33,852,000,000.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	23,999,658,914.30	34,035,977,904.30
21	УРСГАЛ ЗАРДАЛ	23,999,658,914.30	34,035,977,904.30
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	21,839,968,257.30	33,852,000,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	21,839,968,257.30	33,852,000,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	21,839,968,257.30	33,852,000,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,159,690,657.00	183,977,904.30
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	2,159,690,657.00	183,977,904.30
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,159,690,657.00	183,977,904.30
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	1,937,044,144.00	177,197,542.10
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	1,937,044,144.00	177,197,542.10



3.3. Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	26,299,734,444.80	35,142,983,121.86
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,299,734,444.80	1,290,983,121.86
120	Нийтлэг татварын бус орлого	1,299,734,444.80	1,290,983,121.86
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,299,734,444.80	1,290,983,121.86
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,299,734,444.80	1,290,983,121.86
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	25,000,000,000.00	33,852,000,000.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	25,000,000,000.00	33,852,000,000.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	25,000,000,000.00	33,852,000,000.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	26,299,734,444.80	35,142,983,121.86
21	УРСГАЛ ЗАРДАЛ	26,299,734,444.80	35,142,983,121.86
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	24,140,043,787.80	34,927,114,926.22
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	24,140,043,787.80	34,927,114,926.22
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	24,140,043,787.80	34,927,114,926.22
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,159,690,657.00	215,868,195.64
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	2,159,690,657.00	215,868,195.64
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,159,690,657.00	215,868,195.64
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	0.0	0.0
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	0.0	0.0
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.0	0.0
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.0	0.0



3.4. Аудит хийгдсэн ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл			3,142,612,070.21	3,142,612,070.21
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			49,400,000.00	49,400,000.00
Дахин илэрхийлсэн үлдэгдэл			3,192,012,070.21	3,192,012,070.21
Тайлант үеийн үр дүн			1,937,044,144.04	1,937,044,144.04
2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл			5,129,056,214.25	5,129,056,214.25
2017 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл			5,129,056,214.25	5,129,056,214.25
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				
Дахин илэрхийлсэн үлдэгдэл			5,129,056,214.25	5,129,056,214.25
Тайлант үеийн үр дүн			177,197,542.10	177,197,542.10
2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл			5,306,253,756.35	5,306,253,756.35

3.5. Аудит хийгдсэн ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэл	Зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	33,852,000,000.00	28,883,384,670.15	4,968,615,329.85	85.3
21	УРСГАЛ ЗАРДАЛ	33,852,000,000.00	28,883,384,670.15	4,968,615,329.85	85.3
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	33,852,000,000.00	28,883,384,670.15	4,968,615,329.85	85.3
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	33,852,000,000.00	28,883,384,670.15	4,968,615,329.85	85.3
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	33,852,000,000.00	28,883,384,670.15	4,968,615,329.85	85.3
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	33,852,000,000.00	28,883,384,670.15	4,968,615,329.85	85.3
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	33,852,000,000.00	28,883,384,670.15	4,968,615,329.85	85.3
310001	Улсын төсвөөс санхүүжих	33,852,000,000.00	28,883,384,670.15	4,968,615,329.85	85.3

